





2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
“СОНО ФИНТЕК ББСБ” ХХК







ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД


2025 оны онцлох



1-P CAP

Зээлийн эргэн төлөлтийн ахлах менежерийн сонгон шалгаруулалт

Халамжтай СОНО өдөрлөг



3-P CAP

- ★ ХХЗ-ийн ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээг Рико системд нэвтрүүлэв.



5-P CAP

- ★ Хүүхдийн баярын арга хэмжээ
- ★ "Танд баярлалаа" аян



7-P CAP

- ★ Байгууллагын бүх ажилчид ХХЗ хариуцан KPI батлуулж ажиллав
- ★ SONO Invite
- ★ Бүх харилцагчдыг БЛОК жагсаалтаас гаргав.



9-P CAP

- ★ Хичээлийн шинэ жилийн цалинтай чөлөө
- ★ SONO Hiking Day өдөрлөг



11-P CAP

- ★ Google Pay x Кредит карт нээлт
- ★ Sono play / Дотоод
- ★ Happy Pepero Day
- ★ "Best of Youth" шагнал
- ★ Зээлийн практик мэтгэлцээн 2025



2-P CAP

- ★ Дээлтэй СОНО арга хэмжээ
- ★ Байгууллагын номын санг өргөжүүлэв



4-P CAP

- ★ Welcome to SONO FAMILY арга хэмжээ
- Мэдээллийн аюулгүй байдлын сургалт



6-P CAP

- ★ Ойн баярын үйл ажиллагаа
- ★ Ажилчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээ, шинжилгээ, зөвлөгөө
- ★ Цагийн ажилтан - Зуны хөтөлбөр
- ★ Талархал арга хэмжээ



8-P CAP

- ★ Итгэлцлийн үйлчилгээ
- ★ Нийт 700 гэрээг шинэчлэв.
- ★ Хоцролтгүй хамт олон аян
- ★ Ажилчдын CS2 тэмцээн
- ★ Хуулийн зохицуулалт сургалт



10-P CAP

- ★ Зээлийн эрх 4,000,000₮ болов
- ★ Ажилчдын Спорт заалыг хэрэгжүүлж эхлэв
- ★ HALLOWEEN FOOD
- ★ HALLOWEEN PARTY
- ★ Ажилчдын QUIZ NIGHT
- ★ SONO COMICS



12-P CAP

- ★ Apple Pay x Кредит карт нээлт
- ★ Sono play / гадаад
- ★ Ажилчдын шинэ жил
- ★ МББСБХ - "Шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээтэй ББСБ" шагнал
- ★ Sono Claus аян

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

ISO / IEC 27001:2022 СЕРТИФИКАТ



11

Харилцагч, хамтрагч байгууллагуудынхаа өмнө хүлээсэн хариуцлагынхаа хүрээнд мэдээллийн аюулгүй байдлаа анхаарч дотоодын бүхий л мэдээллийн хөрөнгийн албан ёсны лиценз зөвшөөрөлтэй программ хангамж, гаднын халдлагаас хамгаалах галт хана болон антивирусны программыг бүрэн нэвтрүүлж техник хангамж, аюулгүй байдлын нөхцөлийг сайжруулан олон улсын ISO/IEC 27001:2022 стандартын 3 дахь жилдээ аудитад амжилттай орж “маш сайн” үнэлгээг авсан. Мөн Кибер аюулгүй байдлын тухай хуулийн дагуу кибер эрсдэлийн үнэлгээг хоёр жил тутамд хийх шаардлагын дагуу дотооддоо хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа СЗХ-нд хуулийн хугацаанд хүргүүлсэн.



Цахим итгэлцлийн үйлчилгээг шинээр нэвтрүүлснээр үндсэн систем дээр итгэлцлийн үйлчилгээтэй холбоотой нийт 4 цэс, 6 тайлан нэмэлтээр хийгдсэн ба аппликейшн дээр 4 удаагийн сайжруулалт оруулсан. Мөн харилцагчтай байгуулах цахим гэрээ болоод цахим итгэлцлийн нөхцөлийг батлуулсан.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД •

SONO PAY



Sono pay нь бүхий л төлбөрийн хэрэгсэл болон санхүүгийн хэрэгцээг багтаасан үйлчилгээг харилцагчдад санал болгохоор ажиллаж байгаа бөгөөд үүнийг харилцагчдаа мэдрүүлэх, зах зээлд танигдах тал дээр ажилласан бөгөөд мөн хамгийн эхний ажил болох CREDIT CARD болон GOOGLE PAY-г зах зээл амжилттай танилцуулж, мэдлэг олгох ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэж байна.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД •

SONO PAY

Sono Credit картыг Google Wallet-д болон Apple wallet-д холбож, төлбөрөө хялбар шийдэх боломжтой бөгөөд орчин үеийн төлбөрийн шийдлүүдийг харилцагчдадаа хүргэн, илүү ухаалаг, хялбар, найдвартай санхүүгийн шийдлийг бий болгохоор зорьж байна.



Маркетинг
идэвхжүүлэлт



КОНСЕПТ

Google pay-н концептыг Applepay, Googlepay, Kakaopay-с санаа авч гаргасан бөгөөд хар болон цагаан өнгийг брэнд өнгөө болгосон нь хүч чадал, official, цэвэрхэн байдлыг илэрхийлнэ.



КОНСЕПТ

Sono Egg-н концепт нь улаан өндөг бөгөөд брэнд өнгөнөөс ондоо болгосон нь харилцагчдад илүү гүн бөгөөд шинэлэг мэдрэмж төрүүлэхэд чиглэсэн бөгөөд нэршлийн хувьд өндөг нь удаан хугацаанд анхаарал халамж авсны эцэст хүссэн зүг рүүгээ нисэх шувуу болж чадах бөгөөд бидний санхүүгийн бүтээгдэхүүн ч мөн адил харилцагчдыг хаашаа ч нисэж чадах хүч өгөх арга хэрэгсэн мөн юмаа гэдгийг мэдрүүлэхийг зорьсон



ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН АЖИЛ

Бид Sono egg-н идэвхжүүлэлтийг ажлыг сегментэд бодитой хүргэхийн тулд шинэ пэйж нээсэн бөгөөд одоогоор 5,607 followers цуглуулсан байна. Анхны идэвхжүүлэлтийн ажил болох “ХӨРӨНГӨӨ ӨСГӨ” уриа доор контентуудаа амжилттай гаргасан бөгөөд цаашид илүү branding дээр ажиллаж контентуудаа төгөлдөржүүлэхээр ажиллаж байна.

Нийт орсон постер


16


Нийт орсон рийл

2

Нийт хандалт

812,300





Оруулсан мөнгөн дүн

1,562,711,319

Итгэлцэл нээсэн
харилцагчдын тоо

2,496

SONO COMICS

Бид харилцагдаа илүү ойр байж илүү гүн сэтгэгдэл үлдээх тэдэнд хөгжилтэй дурсамж бий болгож Монголын зах зээлд илүү бүтээлч маркетингийн арга хэрэгслийг ашиглах зорилгоор энэхүү төслийг эхлүүлсэн бөгөөд одоогоор Season 1 болон 2 нийлсэн 13 chapter гаргаад байна. Мөн харилцагчдад уншихад илүү хялбар болгох илүү бүтээгч болгохын тул үндсэн пэйжээс хараат бус идэвхжүүлэлтийн суваг ашиглаж байна.

Идэвхжүүлэх постер

6ш

Оруулсан рийл


2ш

Chapters

16ch.

Нийт хандалт

651,531





АМАРХАН

Бид 2025 оны турш бүхий л контент болон хэвлэл идэвхжүүлэлтийн сувгуудаараа дамжуулан харилцагчдаа ЗЭЭЛ АВАХ АМАРХАН концептыг хоногшуулахын зорьж ажилсан



СОНОТОЙ АЯЛЦГААЯ

Наадам болон аялал зугаалгын улиралтай уялдуулан СОНОТОЙ АЯЛЦГААЯ аяныг зарласан



ХАМГИЙН ХАМГИЙН

Бид контентуудаа төгөлдөржүүлэх зорилгоор энэхүү цуврал контентуудыг гаргасан бөгөөд анх төсөөлж байсан хандалтаас өндөр гарсан нь энэхүү цувралыг урт хугацааны турш тогтмол гаргах сэдлийг бий болгоод байна.



ОНЦЛОХ ӨДРҮҮД

Пэйжийн хандалт болон хоногшуулалт хийх зорилгоор Дэлхийн онцлох өдрүүдийг тайлбарын цуг харилцагчдад амжилттай хүргэсэн.

ТАНД БАЯРЛАЛАА

Харилцагчид болон ажилчдаа эерэг сэтгэгдэл төрүүлэх дотоод уур амьсгал болон эргэн төлөлтийг дэмжих зорилгоор энэхүү аяныг эхлүүлсэн бөгөөд дотооддоо 98 постер социал дээр 10 гаруй постер хийж гүйцэтгэсэн бөгөөд ХНХ хамтран дотоод идэвхжүүлэлтийн аяныг амжилттай хийж гүйцэтгэсэн.



Танд
баярлалаа


Дотоод үйл
ажиллагаа




ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

СУРГАЛТ




СЭТГЭЛ ХАНАМЖ



АЖИЛ МЭРГЭЖИЛ

Нийт ажиллагсдын 58.8% хувь нь банк, санхүү болон хууль эрх зүйн мэргэжилтэй бөгөөд үлдсэн 41.2%-ийг бусад мэргэжлүүд зонхилж байна. Үүнд манай ажил мэргэжлийн онцлог харагдаж байгаа бөгөөд санхүүгээс өөр мэргэжилтэй ажилтнуудад санхүүгийн суурь мэдлэг болон нэмэлт мэдээллүүдийг төлөвлөгөөний дагуу ордог.

НАСНЫ БҮЛЭГ



ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА •

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Бид хөдөлмөр эрхлэлтийн харилцааны соёлыг дээшлүүлэн ажлын байрны эрх тэгш байдал болоод байгууллагын дотоод соёлыг бий болгох чиглэлээр стратеги бодлогоо барьж ажиллалаа



ЧӨЛӨӨТ ЦАГ

Ажлын байрны тав тух, уур амьсгал, дотоод соёл бол өсөлт хөгжлийн тулгуур юм. Амралтын танхим, дартс, ширээний хөл бөмбөг, ханын турник зэргийг байрлуулан спорт арга хэмжээг тогтмол зохион байгууллаа



АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНД

Байгууллагын голлох хүчин зүйл болох ажиллах нөөцийг бүтэн биеийн эрт илрүүлэг, шинжилгээнд хамрууллаа



МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хандах эрхийн бодлогыг хэрэгжүүлж шат дараалсан систем бий болгосон



ӨГЛӨӨНИЙ ЦАЙ

Бид нийт ажилтнуудынхаа эрүүл мэндэд түлхүү анхаарч ажлын 5 өдөр өглөөний цай хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ



АЖИЛТНЫ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ

Ажилтны хөндөлттэй зээлийн бодлого журмыг 2023 оноос хэрэгжүүлж нийт 30 гаруй ажилтанд 6% хүүтэй байр орон сууцны зээлийн урьдчилгаа, автомашин худалдан авах зорилгоор олгох 1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг төсөвлөн зээл олгож, 2025 онд 7 ажилтанд зээл олгогдож амьдралын баталгаа болсон орон сууцтай болоход дэмжлэг үзүүлсэн.

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Зарлагдсан 25
төрлийн
ажлын байр



64 удаагийн
ажлын
байрны зар
байршуулж



7492 ажил
горилогчын
анкетаас



25-н ажлын
байранд
амжилттай
сонгон
шалгаруулалт
хийж



113 ажилтан
Сонгон
шалгаруулж



Амжилттай 66-н
ажилтанг
жинхлэж:

“

Ажлын байрны зарыг 2 төрлийн байгууллагаар зарласан. Энэ онд Шинээр Talentsnipe байгууллагатай 1 жилийн үнэгүй эрх нээлгэж хамтран ажилласан. Мөн бусад боломжит сувгуудыг ашиглаж ажлын байрны зар байршуулсан. /POSTER,STORY,FB groups/

Нийт 113 хүн ажилд сонгон шалгаруулж авснаас 66 ажилтан үндсэн ажилтан болсон байна.

Үүнээс 50 front office-н ажилтан бол 16 back office-н ажилтан байна. 2025 онд Шинээр Хэлтэс-1, Хэлтсийн захирал-2, Ахлах менежер-2, Албан тушаал-5 /1 бүтэц, 9 ажлын байр/

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОТООД ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ХҮҮХДИЙН БАЯР

Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Sono Fintech компанийн зүгээс ажилтнуудынхаа хүүхдүүдэд бэлэг гардууллаа.



ТАНД БАЯРЛАЛАА АЯН

Хэлтэс хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгын хүрээнд Sono Fintech компанийн бүх хэлтэс хамрагдсан уулзалт, нээлттэй ярилцлага амжилттай зохион байгуулагдсан өдөрлөг



ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ

Компанийн зүгээс ажилтнуудынхаа эрүүл мэндэд онцгой анхаарч, цаашид урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахад санхүүгийн дарамтгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.



СПОРТ ЗААЛ

Компанийн зүгээс ажилтнуудынхаа эрүүл мэндэд онцгой анхаарч, цаашид урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахад санхүүгийн дарамтгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.



CS2-ИЙН ТЭМЦЭЭН

Залуучуудын хоббиг дэмжих, ажлын стрессийн бууруулах, идэвхжүүлэх зорилгоор залуусын дунд CS2-ийн тэмцээн зохион байгуулж ялагч багт мөнгөн шагнал олгосон.



ТАЛАРХЛЫН ХАЙРЦАГ

Ажилтан бүр урмын үгээр бие биедээ бэлэг барих, хэн нэгнийхээ тусалсан дэмжсэн сайхан сэтгэлийн хариуд үгийн сайхнаар хариу барих аян тогтмол хэрэгжиж байна.

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОТООД ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



HAPPY HALLOWEEN

Ажилтнуудын бүтээлч өвөрмөц сэтгэлгээг сайжруулах, багийн ажиллагаа оролцоог хангах зорилгоор баг бүрд мэндчилгээ, контент бүтээх, дүрд хувирах, өрөөнүүдээ чимэглэх зэрэг даалгаврууд өгөгдөж мөн өдөрлөгийн үеэр хөгжөөнт уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулж урамшуулах ажлууд явагдсан. Энэхүү ажил нь жил бүр уламжлал болон хийгддэг бөгөөд ажилтнууд идэвх санаачилгатай оролцдог ажлуудын нэг болж чадсан



HIKING DAY

Ажилтнуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягт уриалах" зорилгоор нэг өдрийг хамтдаа эрч хүчтэй ,цоглог өнгөрөөх аяллыг залуу ажилтнууд өөрсдөө санаачлан зохион байгуулдаг уламжлалтай.



6TH ANNIVERSARY

Байгууллагын ойн баярын хүрээнд жил бүр "Зуны зугаатай аялал"-н үйл ажиллагааг 2-3 өдрөөр ажилтнуудад амралт, эрч хүч, багийн ажиллагаанд суралцуулах зорилгоор зохион байгуулдаг. Энэ уламжлалын дагуу 120 гаруй ажилтнууд хамрагдан спортын тэмцээн уралдаан, монгол ёс заншлын асуулт хариулт, авхаалж самбаа сорьсон 10 гаруй төрлийн үйл ажиллагаанд хамрагдан баяр хөөр урам зориг дүүрэн аялалд оролцсон.

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

ДОТООД ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ДЭЭЛТЭЙ СОНО

Монгол уламжлалаа дээдлэх таниулах, бие биеэ хүндэтгэх, халуун дотно яриа өрнүүлэн ярилцах, хөгжилдөн наадах, ажлын байрандаа Үндэсний сайхан хувцсаа өмсөн ажиллах өдөрлөгийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн.



PEPERO DAY

Жил бүр Pepero өдрийн 11 сарын 11-ний өдөр зохион байгуулдаг. Тус ажил нь Нэг нэгэндээ талархал илэрхийлэх, Эерэг мэдрэмж ээ түгээдэг. Баг хамт олны уур амьсгал эерэг болгох зорилготой Дотоод идэвхжүүлэлтийн үйл ажиллагаа юм.



ХАЛАМЖТАЙ СОНО АЯН

Залуу ажилтнууд өөрсдөө санаачлан сэтгэлийн бэлэг, халуун дотно тэврэлт, бие биедээ илүү таньж мэдэх, хамт олны харилцаа хандлагад эергээр нөлөөлөх ажлыг амжилттай зохион байгуулж идэвхжүүлэлт нөлөөллийн үр дүнтэй ажил хийгдсэн.

ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА •

GOOD WORKPLACE WARDS



ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ



Мэдээллийн хөрөнгийн хамгаалалтын системийн хяналт мониторинг (Data Loss Prevention - DLP) систем бүрэн хэрэгжиж мэдээллийн урсгалыг хяналт хаалтуудыг хийн хэрэгжүүлсэн.



Халдлагаас хамгаалах галт хананы системийн хяналтыг улам сайжруулан хэрэглэгчдийн бүлэглэл хийн хэрэгжүүлж хориотой болоод бусад ажлын холбогдолгүй сайтуудыг хаасан.



Антивирус программ нь эцсийн хэрэглэгчийн төхөөрөмж болон дотоод сүлжээний вирус, Ransomware-ийн эсрэг хариу үйлдэл үзүүлэх маш чухал хамгаалалтын систем болсон.



Домэйн серверийн удирдлагын хяналтыг хийснээр ажилтны нууц мэдээллийн хөрөнгийг хамгаалах тусгаарлах боломжуудыг ханган ажиллаж байна.

11

Мэдээллийн системийн болон дэд бүтцийн сүлжээний найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, дотоод ба гадаад сүлжээн дэх кибер аюулгүй байдлын эмзэг байдал хангах зорилгоор мэдээллийн аюулгүй байдлын тусгай программуудыг ашиглаж бизнесийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажилласан.

Эрсдлийн
удирдлага



ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

ГОЛЛОХ ЭРСДЛҮҮД

Гол эрсдэлүүд	Эрсдэлийн үр дагавар, нөлөөлөл	Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
Зах зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Дэлхий даяар төв банкууд бодлогын хүүний түвшинг бууруулах хандлагатай байгаа бөгөөд энэ нь банкуудад хүүний орлого, зээлийн эрсдэлд нөлөөлнө. <input type="checkbox"/> Орос-Украины мөргөлдөөн, бүс нутгийн тогтворгүй байдал зэрэг нь эрчим хүч, валютын ханш, нийлүүлэлтийн сүлжээ болон банкны ашигт нөлөөлөх магадлалтай. 	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Хүүний орчин, валютын ханшийн хэлбэлзэл, макро эдийн засгийн өөрчлөлтөөс үүсэх болзошгүй алдагдлыг бууруулах зорилгоор актив, пассивын зохистой харьцааг хадгалж, багцын өсөлтийг хянамгай удирдсан. <input type="checkbox"/> Геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалсан валютын болон эх үүсвэрийн эрсдэлийг бууруулах чиглэлээр эх үүсвэр, активын удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, хөрвөх чадвар, санхүүгийн тогтвортой байдлыг ханган ажилласан.
Санхүүгийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Зохистой харьцааны үзүүлэлт алдагдах; <input type="checkbox"/> Төлбөрийн чадвар алдагдах буюу Хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох; <input type="checkbox"/> Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох; <input type="checkbox"/> Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах; 	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Төлөвлөлт сайн хэрэгжүүлсэн. <input type="checkbox"/> Тогтмол тайлагнал хийж байв. <input type="checkbox"/> Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн. <input type="checkbox"/> Эх үүсвэрийн төвлөрлийг удирдсан. <input type="checkbox"/> Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулсан бодлого чиглэл баримталж ажиллалаа.
Зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Зээлийн багцын чанар буурах; <input type="checkbox"/> Зээл төлөгдөхгүй байх магадлал болон зээлийн алдагдал үүсэх магадлал нэмэгдэх; 	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Харилцагчдыг үнэлэх замаар зэрэглэл тогтоон эрсдэлийн удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулж ажиллаж байна. <input type="checkbox"/> Зээлийн хэлтсийн бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн үр дүнтэй арга хэмжээг авч ажиллалаа.
Үйл ажиллагааны эрсдэл	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Биет эд хөрөнгийн зардал; <input type="checkbox"/> Бизнесийн үйл ажиллагааны тасалдал; <input type="checkbox"/> Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал); <input type="checkbox"/> Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй нэр хүндийн гэх мэт); 	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Дотоод хяналтын нэгжийн байгуулан байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг ханган ажиллалаа. <input type="checkbox"/> Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гадаад, дотоод эрсдэлийг үнэллээ.
Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Мэдээлэл алдагдах, түүнийг буруугаар ашиглах; <input type="checkbox"/> Мэдээллийн бааз гэмтэх, устах, мэдээлэлд хандах боломжгүй болох; <input type="checkbox"/> Системийн эмзэг байдлыг ашиглах 	<ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, түүнтэй холбоотой журмуудыг шинэчлэн баталлаа. <input type="checkbox"/> Системийн эмзэг байдал, цахим халдлага зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлж тогтмол аюулгүй байдлын тест явуулж холбогдох техник, технологийн шинэчлэлт хийж арга аргачлалд сайжруулалт хийлээ.
Байгаль орчин, нийгмийн хариуцлага	Финтек үйл ажиллагааг явуулахад байгаль орчинд нөлөөлөх эрсдэл бусад салбартай харьцуулбал харьцангуй бага;	Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахдаа хууль, хянан нийцүүлэлт болон байгаль орчин нийгэмд эрсдэлтэй эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргадаг. Цаашид байгаль орчинд ээлтэй ногоон зээлийн бүтээгдэхүүн гаргахаар ажиллаж байна.

**Mongolian Investment
Rating Agency**

BBB

Үнэн зөв, бодитой аргачлалд суурилан тогтоосон зээлжих зэрэглэл нь хөрөнгө босгоход дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн хөгжлийг дэмжих, тогтвортой өсөлтийг бий болгох, цаашлаад зээлийн хүүг бууруулах зэрэг ач холбогдолтой юм.

Зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээ нь хөрөнгө оруулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж зохистой шийдвэр гаргахад тусална гэж бид харж байна.

2025 оны 3-р улирлын байдлаар “Соно Финтек ББСБ” ХХК нь байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийг МИРА агентлагаар –BBB -с BBB (Хөрөнгө оруулалтын зэрэглэл) үнэлгээ болгон 1 шат дээшлүүлэн тогтоолгосон байна.

Ингэснээр тус зээлжих зэрэглэлийг ашиглан дахин 80 тэрбум төгрөг хүртэлх бондыг гаргах боломжтой боллоо.

Компанийн засаглал




“Компанийн засаглалын кодекс”-ийн
хэрэгжилтийн үнэлгээ


95%

- Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:
- Авбал зохих нийт онооны 90% болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 50-69% байвал хангалтгүй засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 70-89% байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай;

КОМПАНИЙ ЗАСАГЛАЛ



ТӨЛӨВЛӨГӨӨ
ГҮЙЦЭТГЭЛ



ТӨЛӨВЛӨГӨӨ ГҮЙЦЭТГЭЛ .

Гүйцэтгэл
2023

 Харилцагч
792,148 +19%

 Мерчант
460 +190

 Ажилтан
120 +24

Гүйцэтгэл
2024

 Харилцагч
946,003 +16%

 Мерчант
650 +90

 Ажилтан
144 +5

Гүйцэтгэл
2025

 Харилцагч
1,104,807 +19%

 Мерчант
740 +190

 Ажилтан
151 +24